



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 22 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Улаанбаатар марафон-2018” олон улсын
гүйлтийн шүүгч, зохион байгуулагч бэлтгэх
сургалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2017 оны 289 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. “Улаанбаатар марафон” олон улсын гүйлтийн шүүгч, зохион байгуулагч бэлтгэх сургалтыг 2018 оны 05 дугаар сарын 08-09-ны өдрүүдэд Монголын олимпын хорооны хурлын танхимд зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 900.000 /Есөн зуун мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний сургалт, семинарийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа /-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны... дугаар сарын...-ны өдрийн
... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“Улаанбаатар марафон-2018” олон улсын
гүйлтийн шүүгч, зохион байгуулагч бэлтгэх
сургалтын төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багийн ажлын зардал: 2 хоног х 10 цаг 30.000 төг = 300.000 төг	300.000
2.	Заал талбайн зардал	200.000
3.	Бичиг хэргийн зардал	200.000
4.	Сертификат хэвлүүлэх	100.000
5.	Видео бичлэг, анонс	100.000
Нийт дүн		900.000

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Улаанбаатар марафон-2018” олон улсын
гүйлтийн шүүгч, зохион байгуулагч бэлтгэх
сургалтад хичээл заах багш
нарын бүрэлдэхүүн

- | | |
|--|--------------|
| 1. Монголын хэт холын марафон гүйлтийн
холбооны тэргүүн | З.Өнөрбаяр |
| 2. ННБТСХорооны хэлтсийн дарга | А.Болдмаа |
| 3. ННБТСХорооны мэргэжилтэн | Б.Түвшинбаяр |
| 4. ННБТСХорооны хэлтсийн дарга | С.Саранцэцэг |
| 5. МУБИС-ийн багш | Д.Баярлах |
| 6. МУБИС-ийн хөтөлбөрийн албаны дарга | Г.Батцэцэг |